

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР, ЗОЧИД БУУДАЛ, ЖУУЛЧНЫ БААЗЫН ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү журмын зорилго нь аялал жуулчлалын цогцолбор, зочид буудал, жуулчны баазын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлагыг үндэслэн аялал жуулчлалын цогцолбор, зочид буудал, жуулчны баазад үйлчилгээний зэрэглэл тогтоох, олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Зэрэглэл тогтоох, олгох үйл ажиллагаанд Аялал жуулчлалын тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актыг мөрдлөг болгоно.

1.3.Зэрэглэл тогтоох үйл ажиллагаа нь аялал жуулчлалын цогцолбор, зочид буудал, жуулчны бааз өөрийн үнэлгээний тайланд хараат бус шинжээчид хөндлөнгийн үнэлгээ болон энэхүү журамд заасны дагуу баталгаажуулалт хийх үйл ажиллагаа байна.

1.4.Зэрэглэл тогтоох үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална. Үүнд:

1.4.1.оролцогч болон сонирхогч талуудад тэгш, нээлттэй, ил тод байдлыг хангах;

1.4.2.зэрэглэл тогтоох үйл ажиллагаа нь бусдын нөлөөнд үл автах, хөндлөнгийн, хараат бус байх;

1.4.3.бизнесийн болон хувь хүний нууц хадгалах;

1.4.4.шударга, ашиг сонирхлын зөрчилгүй байх;

1.5.Зэрэглэл тогтоолгох хүсэлт гаргагч аж ахуйн нэгж нь 1 буюу түүнээс дээш жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байна.

1.6.Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зэрэглэлээ тогтоолгосон аялал жуулчлалын цогцолбор, зочид буудал, жуулчны бааз нь холбогдох стандартын шаардлага хангаж буй эсэхэд 3 жил тутам хянан баталгаажуулалт хийнэ.

ХОЁР.ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1.Зэрэглэл тогтоох үйл ажиллагаа нь дараах **дөрвөн** үе шаттай явагдана.

Үүнд:

2.1.1.аж ахуйн нэгж зэрэглэл тогтоолгох хүсэлтийг холбогдох баримт материалын хамт ирүүлэх;

2.1.2.баримт, материалын бүрдэлд хяналт хийх;

2.1.3.хүсэлт гаргагч өөрийн үнэлгээний тайлан боловсруулж, ирүүлэх (энэхүү журмын хавсралтаар батлагдсан маягтын дагуу);

2.1.3.мэргэжлийн баталгаажуулалтын эрх бүхий шинжээч хөндлөнгийн үнэлгээ хийх (цаашид “Хөндлөнгийн шинжээч” гэх);

2.1.3.улсын комиссын үнэлгээ хийх;

2.1.4.улсын комиссын хуралдаанаар зэрэглэл олгох эсэхийг шийдвэрлэх;

2.2.Үйлчилгээний чанарын зэрэглэлийн стандартын шалгуур үзүүлэлтийн дагуу дараах зэрэглэлийг олгоно. Үүнд:

2.2.1.аялал жуулчлалын цогцолборыг 1-3 од;

2.2.2.зочид буудлыг 1-5 од;

2.2.3.жуулчны баазыг 1-3 од;

2.3.Зэрэглэл тогтоолгох хүсэлтийг тухайн жилийн нэгдүгээр улиралд багтаан Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээд хүлээн авна.

2.4.Зэрэглэл тогтоолгох хүсэлтэй аж ахуйн нэгж нь хүсэлтээ бичгээр эсхүл цахимаар гаргах бөгөөд дараах материалыг ирүүлнэ. Үүнд:

2.4.1.аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ;

2.4.2.улсын комиссын барилга хүлээлцсэн акт /зөвхөн Барилгын тухай хуулийн 48 зүйлд заасан барилгын хувьд/;

2.4.3.гал түймрийн аюулгүй байдлын үнэлгээ /Галын аюулгүй байдлын тухай хуулийн 18.6-д заасан/;

2.4.4.согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл /Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 15.1-д заасан/;

2.4.5.зэрэглэлийн стандартын дагуу өөрийгөө үнэлсэн өөрийн үнэлгээний тайлан;

2.4.6.газар ашиглах эсхүл эзэмших, өмчлөх эрхийн гэрчилгээ;

2.4.7.тохирлын үнэлгээний гэрчилгээ;

2.4.8.аялал жуулчлалын цогцолбор, жуулчны баазуудын хувьд байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлан /зөвхөн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан үйл ажиллагааны хувьд/.

2.4.9.үйлчилгээний хөлс төлсөн баримт.

2.5.Нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь зэрэглэл тогтоолгох аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээж авснаас хойш ажлын 5 хоногт багтаан материалын

бүрдэл болон хүчин төгөлдөр байдлыг хянан үзэж, шаардлага хангаагүй тохиолдолд хүсэлтээс татгалзах бөгөөд татгалзсан үндэслэлд материалыг хүлээн авахад саад болж буй нөхцөл болон шаардлагатай нэмэлт баримт, бичгийг хэрхэн бүрдүүлэхийг зааж, дахин гаргах боломжоор хангана.

2.6.Нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь хүсэлтийг хүлээн авсан нөхцөлд тухайн аж ахуйн нэгж ажлын 10 хоногт багтаан үйлчилгээний чанарын зэрэглэлийн стандартын шалгуур үзүүлэлтийн дагуу бичсэн өөрийн үнэлгээний тайланг ирүүлнэ.

2.7.Хүсэлт гаргагчийн өөрийн үнэлгээний тайланд II улиралд багтаан хөндлөнгийн шинжээч үнэлгээ хийж гүйцэтгэх бөгөөд үнэлгээний тайлан, дүгнэлтийг Улсын комисст ирүүлнэ.

2.8.Улсын комисс хүсэлт гаргасан байгууллагын өөрийн үнэлгээний тайлан, хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт, тайлан зэргийг үндэслэн аж ахуйн нэгжийн зэрэглэл тогтоох ажлыг жил бүрийн III улиралд багтаан зохион байгуулна.

2.9.Стандартын шаардлага, үйлчилгээний чанарын талаарх хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт, Улсын комиссын гишүүдийн тайлан, дүгнэлтийг үндэслэн комиссын хуралдаанаар зэрэглэл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

ГУРАВ.ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ УЛСЫН КОМИСС, ХӨНДЛӨНГИЙН ШИНЖЭЭЧ, ТЭДГЭЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1.Зэрэглэл тогтоох Улсын комисс (цаашид “Комисс” гэх)-ын бүрэлдэхүүнийг Нийтийн эрх зүйн хуулийн этгээдээс санал болгосны дагуу аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас жил бүр томилно.

3.2.Комиссын дарга аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл, нарийн бичгийн дарга нь Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн төлөөлөл байх бөгөөд комиссын дарга комиссын гишүүн бүртэй гэрээ байгуулж, гэрээнд талуудын эрх, үүрэг, хариуцлага, ажлын нөхцөл, хугацаа, ажлын хөлс, ёс зүйн хэм хэмжээг тодорхой тусгана.

3.3.Комисс дараах 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

3.3.1.онцгой байдал, стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл-2;

3.3.2.аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл-2;

3.3.3.хөндлөнгийн баталгаажуулалтын шинжээч-2;

3.3.3.Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн төлөөлөл-2 (салбар холбоодын төлөөлөл 1)

3.3.4.зочлох үйлчилгээ, ахуйн үйлчилгээний эрдэмтэн, судлаачийн төлөөлөл-1.

3.4.Комиссын дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа заасан хугацаанаас өмнө дуусгавар болсон бол комиссын бусад гишүүдийн саналыг үндэслэн холбогдох байгууллагын төлөөллийг нэр дэвшүүлж томилно.

3.5.Комиссын гишүүд үйл ажиллагаандаа энэхүү журмын 1.4-т заасан зарчмыг баримтлах бөгөөд комиссын гишүүдийн тодруулах асуулт нь шалгуур, шаардлагын хүрээнээс хальсан, аль нэг талыг баримталсан, ялгаварласан байж болохгүй.

3.6.Комисс дараах эрхтэй:

3.6.1.зэрэглэл тогтоох үйл ажиллагааг зохион байгуулах, зэрэглэл тогтоох, хүчингүй болгох шийдвэр гаргах;

3.6.2.зэрэглэл тогтоох үйл ажиллагааны талаар гарсан хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар санал боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

3.6.3.комиссын үйл ажиллагаатай холбогдох зайлшгүй зардлыг төлөвлөн аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжилж, тухайн жилийн төсөвт тусгуулах;

3.6.4.хүсэлт гаргасан байгууллагуудаас зэрэглэл тогтоохтой холбогдох шаардлагатай мэдээ мэдээлэл, судалгааг гаргуулан авах;

3.6.5.комисс хүсэлт гаргасан байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, үнэлэлт, дүгнэлт гаргах;

3.6.6.хөндлөнгийн үнэлгээ хийх баталгаажуулалтын шинжээчийг томилох.

3.7.Комисс дараах үүрэгтэй:

3.7.1.зэрэглэл тогтоолгосон аж ахуйн нэгжийн бүртгэл, тайланг жилд нэг удаа гаргаж аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд хүргүүлэх;

3.7.2.энэхүү журамд заасан үйл ажиллагаатай холбоотойгоор аж ахуйн нэгжийн гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн талаар хариуг хүргүүлэх.

3.8.Комиссын дарга дараах эрхтэй:

3.8.1.комиссын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

3.8.2.комиссын хуралдааныг даргалан явуулах;

3.8.3.комиссын комиссыг гишүүдтэй гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

3.9.3.комиссын үйл ажиллагаатай холбоотой төсөвт тусгагдсан зардлыг хууль тогтоомжид заасны дагуу зарцуулах.

3.9.Комиссны дарга дараах үүрэгтэй:

3.9.1.тухайн комиссын үйл ажиллагааны тайланг хянан баталгаажуулах;

3.9.2.комиссын үйл ажиллагаатай холбоотойгоор иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, хүсэлт, саналыг хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлэх.

3.10.Комиссын гишүүн дараах эрхтэй:

3.10.1.үнэлгээ хийхтэй холбоотой нэмэлт баримт бичиг, материалыг тухайн байгууллагаас гаргуулж авах, үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангагдах;

3.10.2.Комиссын хуралдаанд оролцох, хэлэлцэж буй асуудлаар санал хэлэх, санал өгөхөөс түдгэлзэх.

3.11.Комиссын гишүүн нь дараах үүрэгтэй:

3.11.1.зэрэглэл тогтоолгох хүсэлт гаргасан аж ахуйн нэгжтэй ашиг сонирхлын зөрчилгүй болохоо нотлох;

3.11.2.хүсэлт гаргасан аж ахуйн нэгжээс ирүүлсэн танилцуулга, өөрийн үнэлгээний тайлан, хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт, тайлантай урьдчилан танилцсан байх;

3.11.3.зэрэглэл тогтоох үйл ажиллагаа, стандартын шаардлага хангаж буй эсэхэд үнэн зөв, мэргэжлийн үнэлгээ дүгнэлтийг өгөх, тайлан гаргаж, үнэлгээ хийж дууссанаас хойш 7 хоногийн дотор нарийн бичгийн даргад хүргүүлэх;

3.11.4.холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хувь хүний болон байгууллагын нууцыг хадгалах, мэдээллийг бусдад дамжуулахгүй байх;

3.12.Комиссын нарийн бичгийн даргын эрх, үүрэг:

3.12.1.комиссын хурлын бэлтгэл ажлын зохион байгуулалтыг хангах, хурлын тэмдэглэл хөтлөх;

3.12.2.зэрэглэл тогтоолгох хүсэлт гаргасан аж ахуйн нэгжид зэрэглэл тогтоолгоход хэрхэн бэлтгэх талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх;

3.12.3.хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, холбогдох материалыг комиссын гишүүдэд комиссын хурал товлогдсон өдрөөс ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэх;

3.12.4.комиссын хэлэлцсэн асуудлаар тэмдэглэл хөтлөх бөгөөд дарга, гишүүдээр гарын үсэг зуруулж баталгаажуулах;

3.12.5.комиссоос гарсан шийдвэрийг албажуулах, олон нийтэд мэдээлэх.

3.13.Энэхүү журамд заасан хөндлөнгийн шинжээч нь зочлох үйлчилгээний удирдлага, салбарын чанарын баталгаажуулалт, судалгааны чиглэлээр мэргэшсэн, туршлагатай шинжээч байна.

3.14.Комисс нь хүсэлт гаргасан аж ахуйн нэгж тус бүрт нэг хөндлөнгийн шинжээчийг томилон ажиллуулна.

3.15.Хөндлөнгийн шинжээч зэрэглэл тогтоох төлөвлөгөөний дагуу хүсэлт гаргасан аж ахуйн нэгж дээр биечлэн очиж, зэрэглэлийн тохирох стандартын дагуу үнэлгээ хийнэ.

3.16.Шинжээч хөндлөнгийн үнэлгээ хийсэн тухай дүгнэлт, саналаа комисст хүргүүлнэ.

ДӨРӨВ.КОМИССЫН ХУРАЛ, ЗЭРЭГЛЭЛ ОЛГОХ ШИЙДВЭР ГАРГАХ

4.1.Тухайн аж ахуйн нэгжийн өөрийн үнэлгээний тайлан, хөндлөнгийн шинжээчийн үнэлгээ, дүгнэлт, тайлан, комиссын үнэлгээ, тайлангаас гадна үйлчилгээний чанарын талаарх үйлчлүүлэгчдийн үнэлгээ зэрэгт үндэслэн шаардлага хангасан эсэх дүгнэлтийг комиссын хуралдаанаар хэлэлцэж, аялал жуулчлалын цогцолбор, зочид буудал, жуулчны баазад зэрэглэл олгох шийдвэр гаргана.

4.2.Комиссын хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэрээр хуралдана. Ээлжит хурал нь жилд 2 удаа хуралдах ба шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.

4.3.Комиссын гишүүдийн 75 хувиас дээш буюу 7 гишүүн оролцсон тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно.

4.4.Комиссын гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд ирээгүй тохиолдолд шалтгааныг хурлаас өмнө нарийн бичгийн даргад мэдэгдэх ба хэлэлцэх асуудалтай холбоотой саналаа бичгээр өгч болно. Энэ тохиолдолд хуралд ирснээр тооцно.

4.5.Зэрэглэл тогтоох эсэх асуудлыг хурлаар нээлттэй хэлэлцэж, гишүүдийн ил санал хураалтаар комиссын гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд нууцаар санал хураалт явуулна.

4.6.Комиссын хурлын баталгаажсан тэмдэглэл, шийдвэрийг үндэслэн аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн зэрэглэл олгох тушаал гаргаж, тэмдэг, батламжийг олгоно.

4.7.Энэхүү журмын 4.6-д заасан зэрэглэлийн тэмдэг, батламж нь дараах загвартай байна. Үүнд:

4.7.1.Аялал жуулчлалын цогцолборын зэрэглэлийн тэмдэг нь шар өнгийн дэвсгэртэй, од нь таван хошуу хэлбэртэй хар өнгөтэй, тэмдгийн өргөн нь 40 см, урт нь 60 см байна. Батламж, тэмдгийн бичвэр нь Монгол (Монгол бичиг), Англи хэл дээр бичигдсэн байна.

4.7.2.Зочид буудлын зэрэглэлийн тэмдэг нь шар өнгийн дэвсгэртэй, од нь таван хошуу хэлбэртэй хар өнгөтэй, тэмдгийн өргөн нь 40 см, урт нь 60 см байна. Батламж, тэмдгийн бичвэр нь Монгол (Монгол бичиг), Англи хэл дээр бичигдсэн байна.

4.7.3.Жуулчны баазын зэрэглэлийн тэмдэг нь шар өнгийн дэвсгэртэй, од нь цэцэг хэлбэртэй хар өнгөтэй, тэмдгийн өргөн нь 40 см, урт нь 60 см байна.

Батламж, тэмдгийн бичвэр нь Монгол (Монгол бичиг), Англи хэл дээр бичигдсэн байна.

4.7.4.Аялал жуулчлалын цогцолбор, зочид буудал, жуулчны бааз нь зочин хүлээн авах хэсэгтээ зэрэглэлийн тэмдэг, батламжийг зочдод харагдахуйцаар байрлуулна.

ТАВ. ГОМДОЛ ГАРГАХ, ЗЭРЭГЛЭЛИЙГ БУУРУУЛАХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

5.1.Аж ахуйн нэгж нь комиссоос олгохоор шийдвэрлэсэн зэрэглэлийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлт гаргах эрхтэй.

5.2.Дахин хянуулах хүсэлтийг зэрэглэл олгох холбогдох шийдвэрийг хүргүүлснээс хойш 21 хоногийн дотор бичгээр комисст гаргана.

5.3.Комисс нь дахин хянуулах тухай өргөдлийн дагуу үнэлэх ажлыг тухайн аж ахуйн нэгжийн удирдлагатай хамтарч хийнэ.

5.4.Комиссын хурлаас дахин хянаж гаргасан эцсийн дүгнэлттэй санал нийлээгүй тохиолдолд хүсэлт гаргасан аж ахуйн нэгж хууль тогтоомжид заасны дагуу холбогдох байгууллагад гомдол гаргаж болно.

5.5.Зэрэглэл эзэмшигч аж ахуйн нэгж нь тухайн зэрэглэлийг ахиулах тохиолдолд зэрэглэлээ хүсэлтээ энэхүү журамд заасны дагуу дахин гаргана.

5.6.Зэрэглэл эзэмшигч нь дараах зөрчил гаргасан тохиолдолд зэрэглэлийг бууруулна:

5.6.1.тухайн зэрэглэлийн стандартын шаардлага хангахгүй болсон нь тогтоогдсон;

5.6.2.аялал жуулчлалын цогцолбор, зочид буудал, жуулчны бааз нь стандартын шаардлага хангаагүй барилга, байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, эд хогшил ашиглах, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангахааргүй орчинд ажил, үйлчилгээ явуулж байгаа болох энэхүү журмын 6.2-т үнэлгээ хийхэд тогтоогдсон.

5.7.Дараах тохиолдолд зэрэглэлийг хүчингүй болгоно:

5.7.1.Комиссын хурлаас тухайн аж ахуйн нэгж нь цаашид аялал жуулчлалын цогцолбор, жуулчны бааз, зочид буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулах боломжгүй гэсэн дүгнэлт гаргасан;

5.7.2.тухайн аж ахуйн нэгж татан буугдсан;

5.7.3.зэрэглэлийг бусдад шилжүүлсэн;

5.7.4.стандартын шаардлага хангаагүй талаар үйлчлүүлэгчдээс 5-аас доошгүй гомдол, нотолгооны хамт комисст бичгээр ирсэн;

5.7.5.энэхүү журмын 4.6-ийн үнэлгээний шаардлага хангаагүй;

5.7.6.өөрийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчилсөн.

5.8.Зэрэглэлийг бууруулсан болон хүчингүй болгосон тухай мэдээллийг Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн албан ёсны цахим хуудаст ил, тод нээлттэй байршуулна.

ЗУРГАА. ДЭМЖЛЭГ

6.1.Энэхүү журмын дагуу ангилал, зэрэглэлээ тогтоолгосон аялал жуулчлалын цогцолбор, зочид буудал, жуулчны баазад төрөөс дараах дэмжлэгт хамруулах ажлыг зохион байгуулна:

6.1.1.хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон өөрийн албан ёсны цахим хуудсаар сурталчлах, дотоодын;

6.1.2.дотоодын болон олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцуулах;

6.1.3.аялал жуулчлалын үндэсний болон олон улсын шагналд дэвшүүлэх;

6.1.4.ногоон зээлийн сангийн болон дотоод, гадаадын бусад хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалтад хамруулах;

6.1.5.олон улсын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх;

6.1.6.үндэсний болон олон улсын стандартын шаардлага хангах, ахиулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

6.1.7.хуульд заасан бусад дэмжлэг.

ДОЛОО.ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

7.1.Энэхүү журмын дагуу зэрэглэл тогтоолгох аж ахуйн нэгж нь дараах хувь хэмжээгээр үйлчилгээний хөлсийг төлнө. Үүнд:

7.1.1.аялал жуулчлалын цогцолборын зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөг;

7.1.2.зочид буудал, жуулчны баазын зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөг

7.2.Энэхүү журмын 2.1.2 заасан баталгаажуулалтын шинжээч болон 2.1.3-т заасан Улсын комиссын гишүүний хөлсний хэмжээг Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн жил бүр шинэчилж тогтооно.

7.3.Энэхүү журмын 6.1, 6.2-т заасан үйлчилгээний хөлсөнд хөндлөнгийн шинжээч, комиссын гишүүний тээврийн зардал ороогүй бөгөөд тухайн зардлыг хүсэлт гаргасан аж ахуйн нэгж хариуцна.

7.4.Энэхүү журмын 3.6.3-т заасан комиссын үйл ажиллагаатай холбогдох зайлшгүй зардлыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн жилийн төсөвт тусгуулна.

НАЙМ.БУСАД

8.1.Зэрэглэл эзэмшигч нь холбогдох зэрэглэлийнхээ стандартын шаардлагад нийцсэн ажил үйлчилгээг чанартай явуулна.

8.2.Энэхүү журмыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийтийн эрх зүйн хуулийн этгээд хэрэгжүүлнэ.

8.3.Энэхүү журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

8.4.Энэхүү журмаар зохицуулаагүй бусад харилцааг Аялал жуулчлалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

---oOo---